



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)  
Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)  
Аудитор: Ц.Уртнасан  
Утас: 70376994 Цахим хаяг: [dalaivandarkhan@gmail.com](mailto:dalaivandarkhan@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан болох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн хороо
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

**Агуулга**

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	9
3.Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	11
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	13
4. Аудитын тайлан .....	14
4.1. Ерөнхий зүйл.....	14
4.2. Материаллаг байдал.....	14
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.3.1 Шилэн дансны мэдээлэл .....	15
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	17
5.1 Залруулга .....	17
5.2 Төлбөрийн акт .....	17
5.3 Албан шаардлага.....	17
5.4 Зөвлөмж .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	19



“СЭЛЭНГЭ АЗЗА” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ М.БАТБОЛД ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023-03-15 № СЭА-2023/01-НА-СТА-ТӨА  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь тайлант онд 2,351,335.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,711,080.4 мянган төгрөгийн зардал гарган 576,229.3 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь тайлант онд Зам тээврийн яамнаас улсын болон орон нутгийн чанартай зам засвар арчлалтын ажилд 607,728.2 мянган төгрөгийн санхүүжилт, түр замын ажлын санхүүжилтийн орлого 902,690.0 мянган төгрөг, орон нутгийн зам засварын ажлын тендерийн орлого 511,611.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 329,306.0 мянган төгрөг зэрэг нийт 2,351,335.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн, орлогын төлөвлөгөөг 54.3 хувиар давуулан

СЭА-2023/01-НА-СТА-ТӨА

биелүүлсэн байна. Нийт зардлын гүйцэтгэл 1,711,080.4 мянган төгрөг болж төлөвлөснөөс 208,166.1 мянган төгрөг буюу 13.9 хувиар хэтэрсэн нь сэлбэг материал, шатахууны үнэ нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Д/д	Үзүүлэлт	2021.12.31	43171 /төгрөгөөр/ МЮА 2022.12.31 36
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	63,311,279.09	348,296,175.96
1.1.2	Дансны авлага	312,595,089.63	271,723,284.52
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	9,966,536.81	23,251,619.53
1.1.4	Бусад авлага	-	1,651,247.12
1.1.6	Бараа материал	192,067,495.04	265,275,847.86
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>577,940,400.57</b>	<b>910,198,174.99</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	607,692,507.77	573,401,672.08
1.2.2	Биет бус хөрөнгө	303,438,903.00	302,542,000.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>911,131,410.77</b>	<b>875,943,672.08</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,489,071,811.34</b>	<b>1,786,141,847.07</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	268,895,740.56	23,517,165.43
2.1.1.3	Татварын өр	91,503,992.06	66,333,459.07
2.1.1.5	Богино хугацаат зээл	18,342,466.62	
2.1.1.9	Богино хугацаат бусад өр төлбөр	9,737,632.08	
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>388,479,831.32</b>	<b>89,850,624.50</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	325,147,885.00	325,147,885
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>325,147,885.00</b>	<b>325,147,885.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>713,627,716.32</b>	<b>414,998,509.50</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	507,379,700.00	507,379,700.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	336,173,513.05	336,173,513.05
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	302,542,000.00	302,542,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(370,651,118.03)	225,048,124.52
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>775,444,095.02</b>	<b>1,371,143,337.57</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,489,071,811.34</b>	<b>1,786,141,847.07</b>



## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

		/төгрөгөөр/	
Д/д	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>816,447,623.92</b>	<b>2,347,699,015.50</b>
2	Борлуулалтын өртөг	631,566,122.21	1,651,697,032.62
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>184,881,501.71</b>	<b>696,001,982.88</b>
4	Түрээсийн орлого		3,636,363.63
8	Бусад орлого	67,570,756.67	-
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	207,811,306.49	49,400,738.37
11	Санхүүгийн зардал		525,659.59
12	Бусад зардал	35,687,320.96	9,457,131.92
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	
17	Бусад ашиг ( алдагдал)	-	-
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	<b>8,953,630.93</b>	<b>640,254,816.63</b>
19	Орлогын татварын зардал	895,363.09	64,025,481.66
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>8,058,267.84</b>	<b>576,229,334.97</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>8,058,267.84</b>	<b>576,229,334.97</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>-</b>	<b>-</b>
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>		
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		



## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>507,379,700.00</b>	<b>336,173,513.05</b>	<b>302,542,000.00</b>	<b>(378,709,384.87)</b>	<b>767,385,828.18</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>507,379,700.00</b>	<b>336,173,513.05</b>	<b>302,542,000.00</b>	<b>(378,709,384.87)</b>	<b>767,385,828.18</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				8,058,266.84	8,058,266.84
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>507,379,700.00</b>	<b>336,173,513.05</b>	<b>302,542,000.00</b>	<b>(370,651,118.03)</b>	<b>775,444,095.02</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				19,469,907.58	19,469,907.58
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>507,379,700.00</b>	<b>336,173,513.05</b>	<b>302,542,000.00</b>	<b>(370,651,118.03)</b>	<b>775,444,095.02</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				576,229,334.97	576,229,334.97
Бусад дэлгэрэнгүй орлого					
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>507,379,700.00</b>	<b>336,173,513.05</b>	<b>302,542,000.00</b>	<b>205,578,216.94</b>	<b>1,351,673,429.99</b>



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	2021.12.31	2022.12.31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,077,221,051.59	2,761,521,338.82
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	185,943,973.00	919,855,819.32
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	2,486,804.00
	Татаас, санхүүжилтийн орлого	786,906,667.00	568,302,028.00
	Бусад мөнгөн орлого	104,370,411.59	1,270,876,687.50
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,145,963,433.80	2,385,517,512.38
	Ажиллагчдад төлсөн	380,626,323.48	626,247,531.51
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	130,615,385.94	141,313,836.35
	Бараа материал худалдан авахад төлсөн	88,837,976.90	426,506,108.10
	Ашиглалтын зардалд төлсөн	23,742,674.84	68,865,353.30
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	285,867,730.00	381,648,309.77
	Хүүний төлбөрт төлсөн	7,358,929.45	5,591,183.81
	Татварын байгууллагад төлсөн	114,971,889.19	279,353,871.24
	Даатгалын төлбөрт төлсөн	4,824,624.00	3,706,000.00
	Бусад мөнгөн зарлага	109,117,900.00	452,285,318.30
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(68,742,382.21)</b>	<b>376,003,826.44</b>
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		68,585,800.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		68,585,800.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>(68,585,800.00)</b>
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>155,328,592.00</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		155,328,592.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,833,190.00</b>	<b>177,721,058.62</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		173,671,058.62
	Төлсөн ногдол ашиг	3,833,190.00	4,050,000.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(3,833,190.00)</b>	<b>(22,392,466.62)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(72,575,572.21)</b>	<b>284,984,897.87</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>135,886,851.30</b>	<b>63,311,278.09</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>63,311,279.09</b>	<b>348,296,175.96</b>

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	а/Улсын чанартай авто замын засвар арчлалт	м/төг	440,900.0	642,006.0	(201,106.0)	68.7
	б/Орон нутгийн чанартай замын засвар арчлалт, бусад	м/төг	1,000,000.0	1,656,697.0	(656,697.0)	60.4
	в/Бусад орлого	м/төг	83,000.0	52,632.4	30,367.6	157.7
	<b>Нийт орлого</b>	м/төг	<b>1,523,900.0</b>	<b>2,351,335.4</b>	(827,435.4)	64.8
2	<b>Нийт зардал</b>	м/төг	<b>1,502,914.3</b>	<b>1,711,080.4</b>	(208,166.1)	87.8
	<b>Үүнээс: Удирдлагын зардал</b>	м/төг	<b>317,831.9</b>	<b>284,367.7</b>	33,464.2	111.8
	<b>Үйл ажиллагааны бус зардал</b>		-	<b>72,423.5</b>	(72,423.5)	-
3	Татварын өмнөх ашиг	м/төг	20,985.7	640,255.0	(619,269.3)	3.3
4	Цэвэр ашиг /алдагдал /	м/төг	18,887.1	576,229.3	(557,342.1)	3.3
5	Төсвийн төлбөр	м/төг	343,252.6	466,472.1	(123,219.5)	73.6
	а/Орлогын татвар	м/төг	2,098.6	885.4	1,213.2	237.0
	б/НӨАТ	м/төг	150,000.0	215,224.1	(65,224.1)	69.7
	в/НДШ	м/төг	134,284.8	156,370.7	(22,085.9)	85.9
	г/Хүн амын орлогын албан татвар	м/төг	51,648.0	75,019.2	(23,371.2)	68.8
	д/Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	м/төг	1,800.0	1,729.5	70.5	104.1
	е/Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	м/төг	1,200.0	2,288.9	(1,088.9)	52.4
	ё/Бусад татвар	м/төг	2,221.2	6,194.9	(3,973.7)	35.9
6	Төрийн өмчийн ноогдол ашиг	м/төг	15,516.2	8,759.4	6,756.8	177.1
7	Нийт ажиллагсдын тоо	Хүн	57.0	50.0	7.0	114.0
8	Нийт цалингийн сан	м/төг	516,480.0	542,330.0	(25,850.0)	95.2
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	755.1	903.9	(148.8)	83.5
10	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	м/төг	1.0	0.7	0.3	135.5
11	Хөрөнгө оруулалт	м/төг	115,000.0	62,351.0	52,649.0	184.4
12	Нийт авлага	м/төг	251,891.3	40,871.8	211,019.5	616.3
	Үүнээс: найдваргүй	м/төг	82.4	1,651.2	(1,568.8)	5.0
13	Нийт өглөг	м/төг	465,147.9	623,777.1	(158,629.2)	74.6
	Богино хугацаат өглөг	м/төг	140,000.0	298,629.2	(158,629.2)	46.9
	Урт хугацаат өглөг	м/төг	325,147.9	325,147.9	-	100.0

Аудит	Мөхөмөл	Ажлын	Төрийн	Урьдчилсан
11.11.2022	11.11.2022	11.11.2022	11.11.2022	11.11.2022

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК нь "Олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто зам, төмөр бетон гүүр хоолойн засвар арчлалтын ажлыг хариуцан авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг байнга ханган ажиллахыг эрхэмлэх" гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Зам барилга, засвар арчлалт,
- Гадаад дотоод худалдаа,
- Асфальт бетон үйлдвэрлэл,
- Авто замын тээвэр,
- Механизмын үйлчилгээ,

Тус компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд "хувьцаат компани" гэж бүртгэсэн бөгөөд өмчийн 100 хувийг төр эзэмшдэг төрийн өмчит хувьцаат компани байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК нь Засгийн газрын 2006 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 173 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах..." гэсэн заалттай нийцэж байна.

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг нийт 45,391.5 мянган төгрөгөөр, сарын дундаж цалинг 325.0-350.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7 дахь "...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалттай нийцэж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 141 дугаар тогтоолоор хараат бус 3 гишүүнийг өөрчлөн томилсон бол 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 321 дугаар тогтоолоор төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Ц.Эрдэнэ-Очир, Г.Туул нарыг тус тус томилсон байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор аудит, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороодын дарга

гишүүдийг шинэчлэн баталж төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 5, хараат бус 3, нийт 8 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2022 онд 8 удаа зохион байгуулж компанийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмжийг хэрэгжүүлэх, тендерийн гүйцэтгэлийн баталгаа гаргахад шаардлагатай зээлийн эрх олгох, компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт, гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэх, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, ТУЗ-ийн дэргэдэх дэд хороодыг шинэчлэн томилох, 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах, үндсэн хөрөнгө акталж данснаас хасах, зөвшөөрөл олгох асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой, / *Зам тээврийн яамнаас олгодог зам засвар, арчлалтын санхүүжилттэй холбогдох* /
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн гэх мэт.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК нь 2016 онд боловсруулагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Уг НБББББ-ийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2016 оноос хойш холбогдох хууль, эрхийн актууд, стандартад тодорхой хэмжээний нэмэлт, өөрчлөлт орсон тул эдгээрт нийцүүлэн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	63,311.30	348,296.20	284,984.90
Авлага	320,039.90	271,723.30	-48,316.60
Татвар, НДШ-ийн авлага		23,251.60	23,251.60
Бусад авлага	2,521.70	1,651.20	-870.50
Бараа материал	192,067.50	265,275.80	73,208.30
Үндсэн хөрөнгө	911,131.40	875,943.70	-35,187.70
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,489,071.80</b>	<b>1,786,141.80</b>	<b>297,070.00</b>
Өр төлбөр	713,627.70	414,998.50	-298,629.20
Эздийн өмч	775,444.10	1,371,143.30	595,699.20
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,489,071.80</b>	<b>1,786,141.80</b>	<b>297,070.00</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 284,984.6 мянган төгрөгөөр өссөн нь 1,839,097.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 2,553,080.8 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 271,723.3 мянган төгрөг болж 48,316.6 мянган төгрөгөөр буурсан нь Цагааннуур сумын зам хучилтын тендерийн орлого 108,217.8 мянган төгрөгийн, Зам тээвэр хөгжлийн яамны санхүүжилтийн 23,814.7 мянган төгрөгийн, Пүрэв хаан ХХК-ийн 27,600.0 мянган төгрөгийн зэрэг авлага шинээр нэмэгдэж, ОДНД ХХК-ийн 11,712.6 мянган төгрөгийн, Пи Си Эф ХХК-ний 76,809.3 мянган төгрөгийн, Интерконсалтинг Констракшн ХХК-ийн 10,000.0 мянган төгрөгийн, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын 10,000.0 мянган төгрөгийн зэрэг авлага буурснаас голлон шалтгаалсан байна.

Татвар НДШ-ийн авлага 23,251.6 мянган төгрөгөөр өссөн нь НӨАТ-ын илүү төлөлтөөс шалтгаалсан бөгөөд бусад авлага дансны үлдэгдэл 870.5 мянган төгрөгөөр буурсан нь ажилчдаас авах авлага буурснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 265,275.8 мянган төгрөг болж 73,208.3 төгрөгөөр нэмэгдсэн нь 799,468.0 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 718,524.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, гүйцэтгэх захирлын 2022 оны А/25 дугаар тушаалаар 311.4 мянган төгрөгийн, А/37 дугаар тушаалаар 7,423.4 мянган төгрөгийн бараа материал акталж, данснаас хассанаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 17,250.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ТУЗ-өөс баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгөөр 58,587.3 мянган төгрөгийн Норд бенз маркийн чирэгч толгой, 3,763.4 мянган төгрөгийн зөөврийн компьютер, принтер худалдан авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 498

дугаар тогтоолоор 45,100.0 мянган төгрөгийн суудлын автомашин акталж, данснаас хассанаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 414,998.5 мянган төгрөг болж 298,629.2 мянган төгрөгөөр буурсан нь Цахим Бар Инженеринг ХХК-д өгөх 179,954.5 мянган төгрөгийн, Өргөн говь ХХК-д өгөх 60,000.0 мянган төгрөгийн, ҮЭХ-ны 9,737.6 мянган төгрөгийн, банкны богино хугацаат зээлийн 18,342.5 мянган төгрөгийн зэрэг өр төлбөрүүдийг барагдуулснаас голлон шалтгаалжээ.

Хуримтлагдсан ашиг 576,229.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн ашиг нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу "Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 670 дугаар тогтоолоор "Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,523,900.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,502,914.3 мянган төгрөгөөр, ашгийг 18,887.1 мянган төгрөгөөр тогтоосон байна. Хөрөнгө оруулалтын 5 арга хэмжээнд 115,000.0 мянган төгрөг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,351,335.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,775,106.0 мянган төгрөгийн зардал гарган, 576,229.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

2022 онд Зам тээврийн яамнаас улсын болон орон нутгийн чанартай зам засвар арчлалтын ажилд 607,728.2 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого, 2019 оны түр замын ажлын санхүүжилтийн орлого 902,690.0 мянган төгрөг, орон нутгийн зам засварын ажлын тендерийн орлого 511,611.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 329,306.0 мянган/ *дайрга бутлуур, гэрээгээр хийгдсэн бусад жижиг ажил үйлчилгээ*/ төгрөг зэрэг нийт 2,351,335.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Нийт орлогын гүйцэтгэл 2,351,335.4 мянган төгрөг болж төлөвлөгөөг 827,435.4 мянган төгрөг буюу 54.3 хувиар давуулан биелүүлсэн нь түр замын туслан гүйцэтгэгчийн ажлын санхүүжилтийн орлого 902,690.0 мянган төгрөг, орон нутгийн зам засварын ажлын 5 тендерийн орлого 511,611.2 мянган төгрөгийн орлогоос голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,711,080.4 мянган төгрөг болж төлөвлөснөөс 208,166.1 мянган төгрөг буюу 13.9 хувиар хэтэрсэн нь сэлбэг материал, шатахууны үнэ нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

Тайлант онд цэвэр ашиг 576,229.3 мянган төгрөг болж, төлөвлөгөөг 564,269.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь нийт орлогыг 54.3 хувиар давуулан биелүүлснээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

ТӨБЗГ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 307 дугаар тогтоолын дагуу тайлант оны ногдол ашиг болох 4,050.0 мянган төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна.

#### **4. Аудитын тайлан**

##### **4.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу "Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан, аудиторын туслах Б.Сувд-Эрдэнэ, Б.Цэвэлмаа нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК нь 2022 оны санхүүгийн тайланг "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК-ийн Дархан салбарт 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,722,222.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 17,222.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

МЮА0065 9055436

#### **4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.3.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК нь тайлант хугацаанд оруулбал зохих 175 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" А-1/947 албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, тээвэр шатахуун, шуудан холбооны зардлыг хэмнэх, 2021 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн өглөг, авлагыг бууруулах зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна.

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- *Хэвлэл захиалга, шуудах холбооны зардлыг 3,276.8 мянган төгрөгөөр хэмнэсэн,*
- *Нийт авлагыг 25,935.5 мянган төгрөгөөр, өглөгийг 298,629.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан,*
- *Үйл ажиллагааны үр дүнгээр 576,229.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан,*

#### 4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

“Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын 2022 оны 11 дүгээр 09-ны өдрийн 53 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус компанийн 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 11,341.8 мянган төгрөгийн албан шаардлага, 71,809.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгснөөс хуульчид олгосон ажлын хөлснөөс ХХОАТ, НДШ-ийг суутгаж байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.


мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	11,341.8	1	11,341.8	100.0
Зөвлөмж	3	71,809.3	2	63,919.3	89.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>83,151.1</b>	<b>3</b>	<b>75,261.1</b>	<b>90.5</b>

Өмнөх аудитаар өгсөн хуульчид олгосон ажлын хөлснөөс ХХОАТ, НДШ-ийг суутгах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн аудитын явцад туслах үйл ажиллагааны орлогыг бүрэн гүйцэт мөшгин шалгах боломжгүй байсан учир дараагийн аудитаар нарийвчлан шалгах нь зүйтэй юм.



## 5. Аудитын илрүүлэлт

### 5.1 Залруулга

Аудитаар нийт 748,633.7 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайланд 23,251.6 мянган төгрөгийн татварын авлагыг тайлагнаагүй,
- Өр төлбөр дансны үлдэгдлийг 20,208.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Тайлант оны орлогыг 165,898.4 мянган төгрөгөөр, зардлыг 192,554.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд шинээр худалдаж авсан 68,585.8 мянган төгрөгийн хөрөнгийг болон зээлд төлсөн төлсөн төлбөрийг 4,409.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Бараа материалын тайлангийн эхний эцсийн үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан,
- ААНОАТ-ын тайланд 165,898.4 мянган төгрөгийн орлого илүү тайлагнасан,
- НӨАТ-ын тайланд 102,587.6 мянган төгрөгийн орлого илүү тайлагнасан,
- Цалингийн зардлыг 5,240.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан гэх мэт.

Аудитаар нийт 10,704.3 мянган төгрөгийн зөрчил илэрч, 434.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 1,563.0 мянган төгрөгийн албан шаардлага, 8,706.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

### 5.2 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан жолооч Ц.Цогбадрах, механик Д.Эрдэнэбат, авто гражийн дарга Д.Нямдулам нарын ээлжийн амралттай хугацаанд 434.7 мянган төгрөгийн удаан жилийн нэмэгдэл олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

### 5.3 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргаж, хуульчид олгосон ажлын хөлснөөс **1,563.0** мянган төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаж, тайлагнаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.2-т “ цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;” , Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх “Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй

адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

## 5.4 Зөвлөмж

### 1. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

**1.1 Илрүүлэлт:** Тайлант онд 6,531.0 мянган төгрөгийн сэлбэг, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм..." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

**1.2 Өгсөн зөвлөмж:** Төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

### 2. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

**2.1 Илрүүлэлт:** Албан томилолтын хуудсыг хаалгаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлангүй, унааны зардлын баримтгүй зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 2,175.6 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгож, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Албан томилолтоор ажиллах удирдамж, гүйцэтгэсэн ажлын тайлан зэрэг анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж		Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд татварын авлага тайлагнаагүй	1	23,251.6	1	23,251.6			1	23,251.6				
Өр төлбөр дансны үлдэгдлийг илүү тайлагнасан	1	20,208.4			1	20,208.4	1	20,208.4				
Орлогыг илүү тайлагнасан	1	165,898.4			1	165,898.4	1	165,898.4				
Зардлыг илүү тайлагнасан	1	192,554.1			1	192,554.1	1	192,554.1				
Мөнгөн гүйлгээний тайланд шинээр худалдаж авсан хөрөнгө, зээлд төлсөн төлбөрийг зөрүүтэй тайлагнасан	1	72,995.0			1	72,995.0	1	72,995.0				
НӨАТ-ын тайланд орлого илүү тайлагнасан	1	102,587.6			1	102,587.6	1	102,587.6				
ААНОАТ-ын тайланд орлого илүү тайлагнасан	1	165,898.4			1	165,898.4	1	165,898.4				
Цалингийн зардлыг илүү тайлагнасан	1	5,240.2			1	5,240.2	1	5,240.2				
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>748,633.7</b>	<b>1</b>	<b>23,251.6</b>	<b>7</b>	<b>725,382.1</b>	<b>8</b>	<b>748,633.7</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэмэгдэл цалин илүү олгосон	1	434.7	1	434.7								
Өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан	1	1,563.0			1	1,563.0						
Худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй	1	6,531.0					1	6,531.0				

Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан	1	2,175.6					1	2,175.6	
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>10,704.3</b>	<b>1</b>	<b>434.7</b>	<b>1</b>	<b>1,563.0</b>	<b>2</b>	<b>8,706.6</b>	4317143998 MOA01659035438

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>								